



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ
2017

2001 онд Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Ерөнхий ассамблейн чуулган дээр Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан жил тутам 6 сая гаруй хүний амь насанд хүрч, улс орон бүрт нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж буй Дархлалын олдмол хомсдол (ДОХ), сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэхэд зарцуулах хөрөнгө дайчлах, өргөн цар хүрээтэй хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нягт уялдуулах боломжтой шинэ механизм бүрдүүлэх санаачлага гаргасны дагуу 2002 оны 1-р сард Женев хотноо Глобаль сан байгуулагдсан.

Глобаль сан нь эдийн засгийн хувьд бага, дунд орлоготой орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ тухайн улсын Засгийн газраас зарцуулж буй төсөв, хөрөнгө дээр нэмэлт санхүүжилт олгох, үр дүнд тулгуурласан санхүүжилт хийх зарчим баримталдаг.

2003-2017 онд Монгол улс ДОХ, сүрьеэ, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр нийт 57,9 сая ам.долларын буцалтгүй тусламж авсан.

Глобаль сан нь санхүүгийн дэмжлэг үзүүлж буй бүх орнууддаа төсөл боловсруулах, төслийн хэрэгжилтийг хангах, оролцогч талуудын эрх тэгш байдлыг хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, төслийн хэрэгжилтийн явцад гарч болох аливаа эрсдэлээс сэргийлэх үүрэг бүхий Үндэстний зохицуулах зөвлөл (ҮЗЗ) байгуулах шаардлага тавьдаг.

Үндэстний Зохицуулах Зөвлөл

Глобаль сангийн зөвлөмжөөр ҮЗЗ-ийн бүрэлдэхүүнд дараах салбарын төлөөлөл ордог. Үүнд:

- Засгийн газрын төлөөлөл
- Олон улсын байгууллагын төлөөлөл
- Хоёр талт хамтын ажиллагаатай байгууллагын төлөөлөл
- Шинжлэх ухааны салбарын төлөөлөл
- Залуучууд, хүний эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-ын төлөөлөл

- ДОХ, сүрьеэгийн чиглэлээр ажилладаг ТББ-ын төлөөлөл
- Шашны байгууллагын төлөөлөл
- ДОХ, сүрьеэгийн халдвартай хүмүүсийн төлөөлөл

ҮЗЗ нь өөрийн дүрэмтэй бөгөөд улиралд нэг удаа хуралдаж бүх гишүүдийн хурлаар шийдвэр гаргаж төслүүдийн хэрэгжилтийн явцтай танилцах, санал зөвлөмж өгөх, ажлын төлөвлөгөөг батлах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх ажлуудыг гүйцэтгэдэг.

ҮЗЗ нь Үндэсний хөтөлбөр, стратеги, бусад бодлогын бичиг баримт, үнэлгээний зөвлөмж, стасистик мэдээлэл, судалгааны дүн зэрэгт үндэслэн төсөл боловсруулан Глобаль санд өргөн барьдаг.

Одоо ҮЗЗ нь 21 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Сангийн орон нутгийн агент

Глобаль сан нь улс орон бүрт өөрийн төлөөлөл болгож Сангийн орон нутгийн агент (СОНА)-ыг сонгон ажиллуулдаг бөгөөд СОНА нь төслүүдийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээ, тайланг хянан баталгаажуулах, үнэлгээ өгөх болон дараагийн санхүүжилтийг олгох талаар санал гаргах үүрэг гүйцэтгэдэг.

СОНА нь санхүү, ханган нийлүүлэлт, хяналт үнэлгээ, менежментийн чиглэлээр 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж төслүүдийн хэрэгжилтэд 6 сар тутам үнэлгээ хийх, мэдээллийг газар дээр нь баталгаажуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэж тайланг Глобаль санд явуулдаг.

Үндсэн хүлээн авагч, Салбар хүлээн авагч, Хөтөлбөр зохицуулах нэгж

Глобаль сангаар батлагдсан төслүүдийн Үндсэн хүлээн авагч (ҮХА)-аар Эрүүл мэндийн яам сонгогдож, төслийг батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу хугацаанд нь тасралтгүй, тогтвортой хэрэгжүүлэхээр Глобаль сантай гэрээ байгуулан ажилладаг. ҮХА


нь үйл ажиллагааны чиглэлээс хамааран дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр Салбар хүлээн авагч (СХА) буюу холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажилладаг. Одоогоор нийт 15 СХА, 22 дэд СХА ажиллаж байна.

Глобаль сангаас гаргасан удирдамжийн дагуу СХА-байгууллагыг сонгохдоо:

1. Ил тод, нээлттэй байлгах үүднээс олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарладаг.
2. Хүсэлтээ ирүүлсэн байгууллагуудад Глобаль сангаас гаргасан аргачлалын дагуу хөтөлбөрийн менежмент, санхүү, ханган нийлүүлэлт, хяналт-шинжилгээ үнэлгээний чиглэлүүдээр байгууллагын чадавхийн үнэлгээ хийдэг.
3. Үнэлгээний дүнг Глобаль сангийн тайлангийн маягтад оруулан тус санд явуулж эцсийн шийдвэрийг гаргуулдаг.

ҮХА нь төслүүдийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж, баталгаажуулан Глобаль сан, СОНА, ҮЗЗ, ЭМЯ-нд тайлагнах үүрэг бүхий Хөтөлбөр зохицуулах нэгж (ХЗН)-ийг 2003 онд байгуулан ажиллуулсан. ХЗН нь одоо 20 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

ТӨСЛИЙН БҮТЭЦ



Глобаль сан байгуулагдсанаасаа хойш жил бүр төслийн уралдаан зарлаж ирсэн бөгөөд манай улс эдгээрт идэвхитэй оролцож ДОХ, сүрьеэ, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр 2003 оноос хойш дараах төслүүдийг батлуулж хэрэгжүүлсэн.

ДОХ-ын төсөл

Хугацаа	Төслийн нэр	Төсөв /сая ам.доллар/
2003-2008	Раунд 2. “Монгол улсад ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх Үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх”	3,0
2006-2008	Раунд 5. “Зорилтот бүлэгт чиглэсэн ХДХВ, ДОХ-оос сэргийлэх хөтөлбөрийг өргөжүүлэх ”	1,9
2008-2011	Раунд 2. “Үргэлжлэх шатны төсөл”	5,8
2008-2011	Раунд 7. “Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн “ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, эмчилгээ, тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанаржуулах, эрүүл мэндийн салбарын чадавхийг бэхжүүлэх замаар ХДХВ-ийн халдварын бага тархалтыг тогтоон барих”	1,9
2011-2014	Нэгтгэсэн төсөл. “ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар Монгол улсад ХДХВ-ийн халдварын бага тархалтыг тогтоон барих”	3,9
2015-2017	“ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, тусламж үйлчилгээ, дэмжлэгийг нэмэгдүүлэх Үндэсний хөтөлбөрийг өргөжүүлэх замаар ХДХВ-ийн халдварын бага тархалтыг тогтоон барих”	5,0
		21,5

ТӨСЛҮҮДИЙН ГОЛ ҮР ДҮНГЭЭС, 2003-2017



Оношлогоо	Эмчилгээ	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр
<ul style="list-style-type: none">ХДХВ-ийн халдвар илрүүлэх оношлуур - 1,181,040 ширхэгТэмбүүгийн халдвар илрүүлэх оношлуур - 2,354,489 ширхэг (RPR + TPHA)-ийг нийлүүлсэнХДХВ-ийн ачаалал болон чанарын үзүүлэлт дархлааны эс тоологч автомат тоног төхөөрөмжүүдийг (NubliSENS, FACSCoount, GeneXpert) нэвтрүүлсэн	<ul style="list-style-type: none">2014 он хүртэл Ретровирусийн болон дагалдах халдварын эмийг 100% хангасан (94,900 ам.доллар)Зонхилон тохиолдох БЗДХ-ын эмийг үндэсний хэмжээнд үнэгүй нийлүүлсэн (590,645 ам.доллар)	<ul style="list-style-type: none">23,200 Эмэгтэй биеэ үнэлэгчид9,100 Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд20,000 гаруй хөдөлгөөнт хүн амд хүрч ажилласан (давхардсан тоогоор)

- Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын БЗДХ-ын эмч, лабораторийн эмч мэргэжилтнүүдэд БЗДХ, ХДХВ, ДОХ-ын оношлогоо, эмчилгээний чиглэлээр, эх барих эмэгтэйчүүд, мэс засал, чих хамар хоолой, шүд, хүүхэд зэрэг бусад төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийг ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээний чиглэлээр сургасан.
- ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх хөтөлбөрийг нэвтрүүлж хоёр, гуравдугаар шатлалын бүх эмнэлгүүдийг РЕР (өртөлтийн дараах сэргийлэлтийн цомог)-ээр хангасан. Хөтөлбөрийн үр дүнд ХДХВ-ийн халдвартай 10 эхээс төрсөн 14 хүүхэд халдваргүй төрсөн.
- Төрөлхийн тэмбүүгээс сэргийлэх нэг цэгийн үйлчилгээг 6 дүүрэг, 8 аймагт нэвтрүүлсэн.
- 2006 оноос ХДХВ-ийн халдвар илрүүлэх Сайн дурын зөвлөгөө, шинжилгээний хөтөлбөр нэвтрүүлснээр одоо 32 төв ажиллаж байна.
- Анагаахын их дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх цөм хөтөлбөрийг боловсруулан оруулсан.
- Багш бэлтгэдэг сургуулиудын хичээлийн хөтөлбөрт ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх чиглэлээр цөм хөтөлбөр боловсруулан оруулсан.
- Цусны аюулгүй байдлыг бүх түвшинд хангаж донорын цусанд ХДХВ, тэмбүүгийн шинжилгээг 100% хийдэг болсон. Мөн Цус сэлбэлт судлалын үндэсний төвд зураасан кодын систем нэвтрүүлсэн.
- Эрсдэлт бүлгийн хүн амыг ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг Үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн.
- ХДХВ-ийн халдвараас сэргийлэх “Ажлын байрны хөтөлбөр”-ийг нэвтрүүлсэн.

2015-2017 ОНУУДАД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ

Зорилго:

Зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ, ДОХ, БЗДХ-ын эмчилгээ, тусламж, үйлчилгээг өргөжүүлэх замаар нийт хүн амыг ХДХВ-ийн халдвараас сэргийлэх

Үндсэн хүлээн авагч:

Эрүүл мэндийн яам

Хамрах хүрээ:

Үндэсний хэмжээнд



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД, 2015-2017

Салбар хүлээн авагч


1. Халдварт өвчин судлалын үндэсний төв
2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
3. Залуус эрүүл мэнд, ТББ
4. Төгс бүсгүйчүүд, ТББ
5. Гал голомт үндэсний хөдөлгөөн, ТББ
6. Шинэ өөдрөг амьдрал, ТББ
7. Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг, ТББ
8. Хүүхэд өсвөр үеийг ивээх төв, ТББ

Дэд салбар хүлээн авагч

1. Хамтдаа төв, ТББ
2. Хүний эрх, залуучууд, эрүүл мэндийг дэмжих төв, ТББ
3. Дорноговь аймгийн Чуулсан үгс, ТББ
4. Дорнод аймгийн ЛЭОС, ТББ
5. Сэлэнгэ аймгийн Хатан замнал, ТББ
6. Дархан-Уул аймгийн Эмэгтэйчүүдийн итгэл найдвар холбоо, ТББ
7. Орхон аймгийн Эрхэмсэг оршихуй Эрдэнэт, ТББ
8. Хөвсгөл аймгийн Улаан загалмай хороо
9. Ховд аймгийн Улаан загалмай хороо
10. Өмнөговь аймгийн Говийн ухаан төв, ТББ
11. Баянхонгор аймгийн Хонгорын төгс тэмүүлэл, ТББ
12. Цус сэлбэлт судлалын үндэсний төв
13. Баянзүрх дүүргийн Сэтгэл амар-1 төв
14. Сүхбаатар дүүргийн Сэтгэл амар-2 төв
15. Чингэлтэй дүүргийн Сэтгэл амар-3 төв
16. Баянгол дүүргийн Сэтгэл амар-4 төв
17. Сонгино-Хайрхан дүүргийн Сэтгэл амар-5 төв
18. Цаглашгүй мэдлэг, ТББ
19. Өөдрөг амьдрал, ТББ
20. Сэтгэлзүйн мэдрэмж, ТББ
21. ДОХ, сүрьеэтэй тэмцэх үндэсний сан, ТББ


Санхүүжилтийн 41 хувийг Төрийн байгууллага, 59 хувийг ТББ-аар дамжуулан үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

ХДХВ, ДОХ-ын эсрэг Үндэсний хэмжээнд зарцуулсан хөрөнгө, 2010-2013



Эх сурвалж: ДОХ-ын зарцуулалтын үнэлгээ, 2012, 2014

Төслийн төсөв зардлын ангиллаар, 2015-2017



Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд



Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ), эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ), хар тамхи мансууруулах бодис хэрэглэгч (ХТМБ) зэрэг эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн хөтөлбөр



Нийт хүн ам болон өртөмтгий бүлэгт (өсвөр үе, залуучууд, хоригдол, цэрэг, цагдаа) чиглэсэн хөтөлбөр



ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах



ХДХВ, ДОХ-ын хариу арга хэмжээнд олон салбарын оролцоог хангах, эрх зүйн орчинг бүрдүүлэх



Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон тандалт, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх



Хөтөлбөрийн менежмент


Хүлээгдэж буй үр дүн:

- Нийт хүн амын дунд ХДХВ-ийн халдварын тархалтыг бага түвшинд (<0.1%) тогтоон барих
- ЭБЭ, ЭБҮ-ийн >73%-ийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамруулах, >60%-ийг СДЗШ-д хамруулах
- ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдварын тархалтыг 2014 оны үзүүлэлтээс 5%-аар бууруулах
- ЭБҮ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалтыг 2014 оны үзүүлэлтээс 15%-аар бууруулах
- Сүүлийн удаа үйлчлүүлэгчтэйгээ бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн хувийг 2014 оны үзүүлэлтээс 7%-аар нэмэгдүүлэх

Сүрьеэгийн төсөл


Хугацаа	Төслийн нэр	Төсөв /сая ам.доллар/
2003-2008	Раунд 1. “Монгол улсад сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь”	1,7
2005-2010	Раунд 4. “Үндэсний хэмжээнд сүрьеэтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх нь”	4,1
2008-2011	Раунд 1. “Үргэлжлэх шатны төсөл”	3,5
2010-2011	Раунд 4. “Үргэлжлэх шатны төсөл”	1,3
2011-2016	Нэгтгэсэн төсөл. “ДОТС-ийн хөтөлбөрийг бэхжүүлэн олон эмэнд дасалтай сүрьеэтэй тэмцэх”	16,3
2016.07-2017	“Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах”	5,0
		31,9

Төслүүдийн гол үр дүнгээс, 2003-2015



Сүрьеэгийн илрүүлсэн тохиолдлын 85 хувийг амжилттай эмчлэх Дэлхийн зорилтод манай улс 2009 онд хүрсэн.

ХӨСҮТ-ийн Үндэсний лавлагаа лабораторийн чадавхи нэмэгдсэн. Сорьц тээвэрлэх тогтолцоонд 21 аймгийн 323 сум хамрагдаж 13,949 сэжигтэй тохиолдлоос 674 сүрьеэгийн шинэ тохиолдлыг илрүүлсэн байна.



2006 оноос анх эмэнд дасалтай сүрьеэг өөрийн оронд оношлох, эмчлэх боломжийг энэхүү төслийн хүрээнд бий болгосон. Сүрьеэгийн эсрэг II эгнээний өндөр өртөг бүхий эмийг тасралтгүй ханган нийлүүлж байна. 2006 оноос хойш нийт 1,817 ОЭДС-ийн тохиолдлыг илрүүлсэнээс 1,722 тохиолдлыг нь эмчилгээнд хамруулсан.

Оношлогоо	Эмчилгээ	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр
<ul style="list-style-type: none"> • 3,433,010 ам.долларын лабораторийн урвалжаар хангасан • 2,548,596 ам.долларын тоног төхөөрөмж ханган нийлүүлсэн • 1,817 ОЭДС-тэй тохиолдлыг илрүүлсэн • Hain test, GeneXpert зэрэг сүүлийн үеийн технологийг нэвтрүүлсэн 	<ul style="list-style-type: none"> • Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмийг 100% ханган нийлүүлж байна • 54,838 сүрьеэгийн тохиолдлыг эмчилгээнд хамруулсан • 2006 оноос ОЭДС-ийн эмчилгээг анх нэвтрүүлж 1,722 тохиолдлыг эмчилсэн • ХДХВ/сүрьеэгийн халдвартай 31 тохиолдлыг эмчилгээнд хамруулсан 	<ul style="list-style-type: none"> • Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний ойрын хавьтал болох 75,739 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан • Эрсдэлт бүлгийн 18,615 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан

- Сүрьеэг илрүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт технологи, хурдавчилсан оношлогооны аргуудыг нэвтрүүлсэн.
- Монгол улсын хүн амын дундах Сүрьеэгийн тархалтын түвшин тогтоох судалгааг амжилттай зохион байгуулсан.
- Интернэтэд суурилсан сүрьеэгийн мэдээллийн системийн программ боловсруулж, аймаг дүүргийн сүрьеэгийн диспансеруудад нэвтрүүлж (TUBIS.mn) байна.
- Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах зорилгоор сайн дурын идэвхтэнээр дамжуулан өвчтөний эмийг гэрээр хүргэх, хоолтой эмчилгээнд хамруулах үйл ажиллагааг 2003 оноос нэвтрүүлсэн (Эмчилгээний амжилт 97%).
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилгоор Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан сүрьеэг эрт илрүүлж, шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн (Эмчилгээний амжилт 90%).

2016-2017 ОНУУДАД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ

Зорилго:

2020 он хүртэл сүрьеэгийн тархалтыг 2014 оны үзүүлэлтээс 4 хувиар, нас баралтыг 30 хувиар тус тус бууруулна.

Үндсэн хүлээн авагч:

Эрүүл мэндийн яам

Хамрах хүрээ:

Үндэсний хэмжээнд

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД, 2016-2017

Салбар хүлээн авагч


1. Халдварт өвчин судлалын үндэсний төв
2. Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг, ТББ
3. Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтэнүүдийн холбоо, ТББ
4. ШШГЕГ, Хорих 429-р анги
5. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
6. Монголын сумын эмч мэргэжилтэнүүдийн холбоо, ТББ
7. Монголын улаан загалмай нийгэмлэг, ТББ

Дэд салбар хүлээн авагч

1. Эмнэлгийн эрүүл ахуйн институт, ТББ


Санхүүжилтийн 77 хувийг Төрийн байгууллага, 23 хувийг ТББ-аар дамжуулан үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд Үндэсний хэмжээнд зарцуулсан хөрөнгө, 2013-2014



Эх сурвалж: Сүрьеэгийн тусламж үйлчилгээний санхүүгийн зарцуулалтын үнэлгээ, 2015

Төслийн төсөв зардлын ангиллаар, 2016-2017



ЭМЯ, Глобаль сангийн
дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслүүдийн
Хөтөлбөр зохицуулах нэгж
Хаяг: Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпийн гудамж – 16,
Реженс Резиденс 2 давхар 203 тоот,
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 77126155, 77131328
Факс: 77139732
Э-шуудан: hiv@aids.mn
Вэб: www.aids.mn

ТЭМДЭГЛЭЛ